

## ТАНИЛЦУУЛГА

“Эрчим хүч-3 төсөл” буюу “Багануур-Чойр чиглэлийн 188км 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөх төсөл”-ийн талаар

### **Нэг. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага**

Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий аймгийн эрчим хүчний хэрэглээг “Багануур-Чойр-Айраг-Сайншанд-Замын-Үүд” болон “Багануур-Улаанбаатар” чиглэлийн 110 кВ-ын 1 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам /цаашид “ЦДАШ” гэх/-аар дамжуулан хангаж байна. Энэ нь болзошгүй цахилгаан дамжуулах шугамын гэмтэл, саатал гарсан үед дээр дурдсан аймгуудын 70,740 айл өрх, 46,261 аж ахуй нэгжийн цахилгаан эрчим хүч тасалдах эрсдэлтэй байна.

Тухайн бүс нутагт 114 уул уурхайн эрчим хүч хэрэглэгч байгаагаас гадна ашигт малтмалын томоохон ордууд төвлөрч, цахилгаан эрчим хүчний хэрэглээ 500-600 МВт байгаа бөгөөд ойрын ирээдүйд энэ хэрэглээ 800-900 МВт хүртэл өсөхөөр тооцоологдож байна.

“Эрчим хүч-3 төсөл” буюу “Багануур-Чойр чиглэлийн 188км 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөх төсөл”-ийг хэрэгжүүлснээр одоогийн Багануур-Чойр чиглэлийн 110 кВ-ын ЦДАШ-ын дамжуулах чадварыг нэмэгдүүлж, Багануур, Чойр дэд станцуудыг өргөтгөн эрчим хүчний чанар, найдвартай ажиллагаа, тогтвортой байдал хангагдахаас гадна өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг хангах боломжийг бүрдүүлнэ.

Түүнчлэн, Өмнөговь аймгийн Ханбогд суманд байрлах 250 МВт-ын салхин цахилгаан станц, Говьсүмбэр аймгийн Чойрт байрлах 50 МВт-ын нарны цахилгаан станц, Дундговь аймгийн Мандалговьд байрлах 30 МВт-ын нарны цахилгаан станц, Дорноговь аймгийн Эрдэнэ суманд шинээр хэрэгжүүлэх 30 МВт-ын нарны цахилгаан станцын сэргээгдэх эх үүсвэрүүдийн үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг төвийн эрчим хүчний системд бүрэн нийлүүлэх боломж бүрдэх юм.

### **Хоёр. Төслийн зээлийн хэмжээ, нөхцөл, хамрах хүрээ**

Төсөл хэрэгжүүлэгч: Эрчим хүчний яам

Төсөл хэрэгжих хугацаа: 2024 он–2029 он /5 жил/

“Эрчим хүч-3 төсөл” буюу “Багануур-Чойр чиглэлийн 188км 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөх төсөл”-ийг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкнаас олгох 47.0 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал болох 840.0 мянган ам.долларыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөөд байна.

Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 24.3-т заасны дагуу зээлийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн болно.

Тус банкнаас санал болгож буй зээлийн хөрөнгө нь баталгаат овернайт санхүүжилтийн хувьсах хүү /SOFR/ дээр 1.44 хувийн нэмэгдэлтэй, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн хугацаанд эргэн төлөлт хийх нөхцөлтэй бөгөөд үйлчилгээний шимтгэл зээлийн дүнгийн 0.25 хувьтай тэнцүү байна.

Түүнчлэн, тус банкнаас зээлдэгч орнуудад олгож буй зээлийн нөхцөлийг хөнгөлөх, сайжруулах зорилгоор шинэ санхүүжилтийн арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр баталсан. Ингэснээр өмнөх зээлүүдийн нөхцөлтэй харьцуулахад үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаанд хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр болох 0.25 хувийн шимтгэлийг төлөхгүй байхаар тусгасан анхны төслийн зээл болж байна.

### **Гурав. Бодлогын баримт бичигт туссан байдал**

“Эрчим хүч-3 төсөл” буюу “Багануур-Чойр чиглэлийн 188км 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөх төсөл” нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн доор дурдсан баримт бичигт туссантай нийцэж байгаа болно. Үүнд:

- ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2.35-д “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо болон хөндлөн гол тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг нэгдсэн систем байгуулна” гэж;
- ““Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалт”-ын “Эрчим хүчний сэргэлт” хэсгийн 9-д “Эрчим хүчний дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний төслүүд ... Багануур-Чойр ...” гэж;
- “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.3.29-д “Багануур-Чойр чиглэлийн 220 кВ ...-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, ...” гэж тус тус туссан;

### **Тав. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан.

Энэ хүрээнд 2024-2027 оны хооронд эдийн засаг харгалзан 6.0 хувь, 8.0 хувь, 7.0 хувь, 6.0 хувиар тус тус өсөж, Монгол Улсын 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2024 онд 44.4 хувь, 2025 онд 42.6 хувь, 2026-2027 онуудад 60 хувиас бага байхаар тооцоологдсон. Ингэснээр эдгээр онуудад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.